



I/2022

Тархаасан: 2022 оны 2 дугаар сарын 16



Улсын хэмжээнд 11.1 мянган толгой мал хорогдсон байна

Том малын зүй бус хорогдол 2022 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 11.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 285.5 мянгаар буурсан байна.


Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, ямаа 4.9 мянга, хонь 3.9 мянга, үхэр 1.5 мянга, адуу 799 толгой, тэмээ 11 толгойгоор тус тус хорогдсон байна. Нийт хорогдсон малын 44.2 хувийг ямаа, 35.4 хувийг хонь эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ХОРОГДСОН ТОМ МАЛ, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2019 I	2020 I	2021 I	2022 I	2019 I	2020 I	2021 I	2022 I
	мянган толгой				хувь			
Дүн	25.7	48.6	296.5	11.1	0.04	0.07	0.44	0.02
Адуу	1.7	2.8	14.5	0.8	0.04	0.07	0.35	0.02
Үхэр	2.9	3.9	29.6	1.5	0.07	0.08	0.63	0.03
Тэмээ	0.0	0.0	1.6	0.0	0.01	0.01	0.35	0.00
Хонь	8.8	21.3	86.3	3.9	0.03	0.07	0.29	0.01
Ямаа	12.3	20.6	164.5	4.9	0.05	0.07	0.59	0.02

Хорогдлыг аймгаар нь авч үзэхэд 2022 оны 1 дүгээр сард Хэнтий аймагт 2.1 (18.8 хувь) мянга, Ховд аймагт 2.0 (18.5 хувь) мянга, Баян-Өлгий аймагт 1.5 (14.0 хувь) мянга, Архангай аймагт 1.2 (10.9 хувь) мянган толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 62.2 хувийг эзэлж байна.


ЗУРАГ 1. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, аймаг, нийслэлээр, 2022 оны 1 дүгээр сарын байдлаар, мянган толгой



Улсын хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон 30.8 сая эх малын 3.2 мянга (0.01%) нь 2022 оны 1 дүгээр сард хорогдсон байна. Говь-Алтай, Архангай, Ховд, Хэнтий аймагт хээлтэгч мал 0.2-1.5 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 74.4 хувийг эзэлж байна. Харин 373 толгой хээлтүүлэгч хорогдсоноос бүх 183, хуц 82, ухна 80, азарга 28 тус тус байна.

Улсын хэмжээнд 2022 оны 1 дүгээр сард 634 толгой мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 375 (2.4 дахин их) толгойгоор өссөн байна.

ЗУРАГ 3. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Хорогдсон нийт том малын 94.1 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг шалтгаанаар хорогдсон бол 0.2 хувь нь аюулт үзэгдлээр, 5.7 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол

Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь

Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, Том малын зүй бус хорогдлын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 3 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Э.Болормаа
Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212